

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ
/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын агаарын зайд иргэний агаарын хөлгөөр нислэг үйлдэх, нислэгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Иргэний нисэхийн тухай хууль тогтоомж

2.1. Иргэний нисэхийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Иргэний нисэхийн үйл ажиллагааны үндсэн зарчим

3.1. Иргэний нисэхийн үйл ажиллагаа нь аюулгүй, үр ашигтай, хүртээмжтэй байх зарчмыг баримтална.

4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

4.1. Энэ хууль нь Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагаатай холбоотой дараах харилцааг зохицуулна.

4.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлаж байгаа иргэний агаарын хөлгийн үйл ажиллагаа;

4.1.2. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн үйл ажиллагаа;

4.1.3. Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна нислэг үйлдэж байгаа Монгол Улсын бүртгэлтэй болон Монгол Улсын агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн үйл ажиллагаа;

4.1.4. нисэхийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалт, удирдлагын үйл ажиллагаа;

4.1.5. агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа;

4.1.6. агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалтын үйл ажиллагаа.

4.2. Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэж байгаа Улсын нисэхийн тухай хуульд заасан улсын агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөний зохицуулалт энэ хуульд хамаарахгүй.

5 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

5.1. Энэ хуульд дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1. “Чикагогийн конвенц” гэж Монгол Улс 1989 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр нэгдэн орсон Олон улсын иргэний нисэхийн тухай 1944 оны 12 дугаар сарын 07-ны

- өдөр Чикаго хотноо баталсан олон улсын конвенц болон түүний Хавсралтууд гэж тус тус ойлгоно; /цаашид Чикагогийн конвенц, Чикагогийн конвенцийн хавсралт гэх/;
- 5.1.2. “агаарын зай” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрээс дээшхи хийн мандлын агаарын давхрагын орон зайг;
- 5.1.3. “нислэгийн удирдлагын агаарын зай” гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр агаарын хөлгийн хөөрөлт, буулт, нислэгийг аюулгүй гүйцэтгэх, нислэгийн нам өндрөөс, хяналттай агаарын зайн дээд хязгаар хүртэлх зайг;
- 5.1.4. “агаарын зам” гэж агаарын хөлгийн нислэгийг аюулгүй гүйцэтгэхэд зориулагдсан өндөр ба өргөнөөр хязгаарлагдсан агаарын зайг;
- 5.1.5. “агаарын навигацийн байгууламж” гэж агаарын хөлгийн байршлыг тодорхойлох, хөдөлгөөнийг удирдан чиглүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаанд ашиглагдах барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг;
- 5.1.6. “агаарын навигацийн үйлчилгээ” гэж нислэгийн бүх үе шатанд үзүүлэх нислэгийн хөдөлгөөний зохицуулалт, холбоо, навигаци, ажиглалт, нисэхийн мэдээллийн, нисэхийн цаг уурын үйлчилгээ болон эрэн хайх, авран туслах үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл дамжуулах цогц үйл ажиллагааг;
- 5.1.7. “агаарын тээвэрлэгч” гэж агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний үндсэн дээр агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдийг;
- 5.1.8. “агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ” гэж агаарын хөлгөөр арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэхэд олгож буй тусгай зөвшөөрлийг;
- 5.1.9. “арилжааны агаарын тээврийн үйлчилгээ” гэж зорчигч, ачаа, шууданг нэг цэгээс нөгөө цэг хүртэл агаарын хөлгөөр төлбөртэй тээвэрлэх үйл ажиллагааг;
- 5.1.10. “агаарын хөлгийн дарга” гэж агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн томилсон, тухайн агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хариуцсан нисэгчийг;
- 5.1.11. “агаарын хөлөг” гэж агаарын өгсөх урсгалын нөлөөллөөр бус, өөрөө агаартай харилцан үйлчилсний хүчинд агаарт тогтож, хөдөлгөөн хийж чадах аливаа төхөөрөмжийг;
- 5.1.12. “аэродром” гэж агаарын хөлгийг байрлуулах, хөөргөх, буулгах, явгалахад зориулж тусгайлан тоногдсон газар болон усан гадаргууг;
- 5.1.13. “аэродромын аюулгүйн бүс” гэж аэродромыг байгуулахдаа нислэгийн аюулгүй байдлыг хангах шаардлагыг үндэслэн тогтоосон тодорхой хэмжээний хуурай газар, усан гадаргуу, орон зайг;
- 5.1.14. “аюул тулгарсан агаарын хөлөг” гэж агаарын хөлөг, багийн гишүүд болон зорчигчид аюултай байдал үүсч болзошгүй, эсхүл тусламж шаардлагатай нөхцөл байдалд орсон агаарын хөлгийг;
- 5.1.15. “аюулгүй байдлын зөвлөмж” гэж шинжлэн шалгах ажиллагааны үр дүнд, эсхүл аюулгүй байдлын талаар гаргасан судалгаа болон төрөл бүрийн эх үүсвэрийг үндэслэн агаарын хөлгийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах эрх бүхий байгууллагаас гаргасан баримт бичгийг;
- 5.1.16. “аюулгүйн үзлэг” гэж иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын үндэсний хөтөлбөрийн дагуу агаарын тээвэрлэгч болон нисэх буудлын аюулгүй байдлыг хангах үзлэг шалгалтыг;
- 5.1.17. “аюултай бараа” гэж агаарын хөлгөөр тээвэрлэхэд хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, эд хөрөнгө, эсхүл хүрээлэн буй орчинд эрсдэл учруулж болох эд зүйлс, бодисыг;

- 5.1.18. “зорчигч” гэж багийн гишүүд эсхүл нисэгчээс бусад агаарын хөлөгт зорчиж байгаа этгээдийг;
- 5.1.19. “зөрчил” гэж ослоос бусад агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой аюулгүй байдалд нөлөөлсөн, нөлөөлж болзошгүй нислэгийн нөхцөл байдлыг;
- 5.1.20. “иргэний агаарын хөлөг” гэж Улсын нисэхийн тухай хуульд заасан улсын агаарын хөлгөөс бусад агаарын хөлгийг;
- 5.1.21. “иргэний нисэхийн дүрэм” гэж энэ хууль болон Чикагогийн конвенцийн Хавсралтын суурь түвшинд нийцүүлэн баталсан нисэхийн аюулгүй байдлын зохицуулалтын дүрмийг;
- 5.1.22. “иргэний нисэхийн үйл ажиллагаа” гэж агаарын хөлгийн нислэгийн болон түүнд шаардлагатай бусад үйл ажиллагаа, үйлчилгээг;
- 5.1.23. “иргэний нисэхийн үйлчилгээ” гэж агаарын навигаци, аэродром, нисэх буудал болон аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг;
- 5.1.23. “маягийн гэрчилгээ” гэж агаарын хөлгийн хийц нислэгт тэнцэх чадварын холбогдох шаардлагад нийцэж байгааг Хэлэлцэн тохиролцогч улсын эрх бүхий байгууллагаас тодорхойлж олгосон баримт бичгийг;
- 5.1.24. “Монреалийн конвенц” гэж Монгол Улс 2004 оны 10 дугаар сарын 15-ны өдөр соёрхон баталсан Олон улсын агаарын тээвэрт хамаарах зарим журмыг нэгтгэх тухай 1999 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Монреаль хотноо баталсан конвенцийг /цаашид “Монреалийн конвенц” гэх/;
- 5.1.25. “нислэгт тэнцэх чадвар” гэж агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн нислэгийн аюулгүй байдалд тавигдах шаардлагыг хангаж байгааг;
- 5.1.26. “нислэгийн хөдөлгөөний удирдагч” гэж нислэгийн удирдлагын бүсэд хөдөлгөөний шуурхай, цэгцтэй, аюулгүй байдлыг хариуцсан ажилтанг;
- 5.1.27. “нисэх баг” гэж нислэгийн хугацаанд агаарын хөлөгт нисэгч, нисэх-инженерийн үүрэг гүйцэтгэхээр томилсон ажилтныг;
- 5.1.28. “нисэх буудал” гэж аэродром, зорчигч болон үйлчилгээний барилга байгууламж бүхий цогцолборыг;
- 5.1.29. “нисэхийн аюулгүйн хамгаалалт” гэж Чикагогийн конвенцийн Хавсралт 17-д тодорхойлсны дагуу агаарын тээврийн үйл ажиллагааг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах цогц арга хэмжээг;
- 5.1.30. “нисэхийн мэргэшсэн ажилтан” гэж иргэний нисэхийн дүрмийн дагуу олгосон үнэмлэх, гэрчилгээ эзэмшигчийг;
- 5.1.31. “нислэгийн аюулгүй байдал” гэж нислэгийн үйл ажиллагаа болон түүнд хамаарах бусад үйл ажиллагааг хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд хохирол учруулахгүйгээр гүйцэтгэх нөхцөл байдал болон чадварыг;
- 5.1.32. “нислэг” гэж агаарын хөлөг нислэг үйлдэх зорилгоор зогсоолоос хөдлөхөөс эхлэн хөөрөх, газарт бууж хөдөлгөөнөө бүрэн зогсоох хүртэлх үйл явцыг;
- 5.1.33. “нислэгийн ажилтан” гэж нисэгч, нисэх-инженер, бүхээгийн ажилтан болон инженер техникийн ажилтан, нислэгийн үйл ажиллагааны зохицуулагчыг;
- 5.1.34. “осол” гэж Чикагогийн конвенцийн Хавсралт 13-т тодорхойлсон нислэгийн нөхцөл байдлыг;
- 5.1.35. “олон улсын нислэг” гэж хоёр болон түүнээс дээш улсын агаарын зайд үйлдэх нислэгийг;

- 5.1.36. “орох, гарах цэг” гэж улсын хилийг агаарын замаар нэвтрэх газар зүйн байршлыг;
- 5.1.37. “хамтын ажиллагааны гэрээ” гэж нисэхийн бүтээгдэхүүн болон эрх зүйн баримт бичгийг хүлээн зөвшөөрөх зорилгоор Хэлэлцэн тохиролцогч улсын иргэний нисэхийн эрх бүхий байгууллагатай байгуулсан тохиролцоог;
- 5.1.38. “хувийн нислэг” гэж агаарын хөлөг эзэмшигч хувийн зорилгоор өөрөө тухайн нислэгт оролцож буй, арилжааны бус нислэгийн үйл ажиллагааг;
- 5.1.39. “хэлэлцэн тохиролцогч улс” гэж Чикагогийн конвенцид нэгдэн орсон улсыг;
- 5.1.40. “шинжлэн шалгах” гэж агаарын хөлгийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, нөлөөлсөн хүчин зүйл бүрийг тогтоож, дүгнэлт гарган, аюулгүй байдлын зөвлөмж гаргах үйл ажиллагааг;
- 5.1.41. “шинжлэн шалгах багийн ахлагч” гэж Чикагогийн конвенцийн Хавсралт 13-ын дагуу шинжлэн шалгах ажиллагааг удирдах, хянах, гүйцэтгэхээр томилогдсон шинжлэн шалгагчийг;
- 5.1.42. “эдийн засгийн зохицуулалтын дүрэм” гэж агаарын тээврийн үйл ажиллагааг үр ашигтай явуулах зорилгоор баталсан дүрмийг;
- 5.1.43. “эдийн засгийн зөвшөөрөл” гэж агаарын тээврийн зах зээлийн эрэлт, нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор эрх бүхий этгээдээс агаарын тээврийн үйлчилгээ эрхлэгчид энэ хуулийн дагуу олгосон зөвшөөрлийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

6 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

- 6.1. Улсын Их Хурал иргэний нисэхийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 6.1.1. иргэний нисэхийн тухай хууль, хууль тогтоомжийг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах;
- 6.1.2. төрөөс иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх бодлогыг тодорхойлох;
- 6.1.3. иргэний нисэхийн асуудлаар Олон улсын гэрээнд нийцүүлэн Монгол Улс нэгдэн орох, гарах асуудлыг шийдвэрлэх;
- 6.1.4. Төрөөс иргэний нисэхийн салбарт баримтлах бодлогыг батлах;
- 6.1.5. Агаарын навигацийн хураамжаас нисэхийн аюулгүй байдлыг хангах, иргэний нисэхийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээг жил бүр тогтоож, улсын төсөвт тусгах.

7 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

- 7.1. Засгийн газар иргэний нисэхийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 7.1.1. Монгол Улсын агаарын зайд иргэний нисэхийн асуудлаар онц бүрэн эрхийг Монгол Улсын нэрийн өмнөөс хэрэгжүүлэх;
- 7.1.2. олон улсын нисэх буудал байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг шийдвэрлэх;
- 7.1.3. Засгийн газар хоорондын агаарын харилцааны хэлэлцээрийг батлах;
- 7.1.4. иргэний нисэхийн салбарт хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийг батлах;

7.1.5. иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга бөгөөд Улсын ерөнхий байцаагчийг томилох, чөлөөлөх;

7.1.6. агаарын тээврийн үйлчилгээнд татаас олгох журмыг батлах, шийдвэрлэх;

8 дугаар зүйл. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

8.1. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.1.1. иргэний нисэхийн салбарын хөгжлийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх;

8.1.2. иргэний нисэхийн салбарын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

8.1.3. агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалтыг хэрэгжүүлэх, хяналт тавих;

8.1.4. агаарын навигаци, нисэх буудал, аюулгүйн хамгаалалтын бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх.

9 дүгээр зүйл. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Сайд бүрэн эрх

9.1. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Сайд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1. Монгол Улсад агаарын тээвэрлэгчийн даатгалын бодлогыг тодорхойлох;

9.1.2. Монгол Улсын нислэгийн аюулгүй байдлын бодлогыг тодорхойлох;

9.1.3. иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангуулах;

9.1.4. агаарын навигаци, агаарын хөлгийн буулт, хөөрөлтийн хураамжийн хэмжээг тогтоох;

9.1.5. олон улсын хуваарьт нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчийг томилох;

9.1.6. Засгийн газрын эрх олгосноор зарим хөтөлбөрийг батлах;

9.1.7. олон улсын иргэний нисэхийн байгууллагын зөвлөмжид нийцүүлэн иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба, төрийн өмчит агаарын навигацийн үйлчилгээний байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоог Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах;

9.1.8. агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албаны дарга бөгөөд ерөнхий шинжлэн шалгагчийг томилох, чөлөөлөх;

9.1.9. энэ хууль болон бусад хууль, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрээр олгосон эрхийн дагуу холбогдох албан тушаалтныг томилох, чөлөөлөх;

9.1.10. агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах ажиллагааны дүрмийг батлах;

9.1.11. агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах ажиллагааг шаардлагатай гэж үзвэл холбогдох улсын агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах эрх бүхий байгууллагатай хамтран гүйцэтгэх, эсхүл тухайн байгууллагад хэсэгчлэн, буюу бүрэн шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх;

9.1.12. иргэний нисэхийн дүрмийг батлах;

9.1.13. эдийн засгийн зохицуулалтын дүрмийг батлах;

9.1.14. эдийн засгийн зөвшөөрөл олгох;

9.1.15. иргэний нисэхэд ашиглах агаарын зай, агаарын зам болон тусгай зориулалтын бүсийг холбогдох эрх бүхий байгууллагатай зөвшилцөн тогтоох;

9.1.16. аэродромыг ангилах, бүртгэх журмыг батлах.

10 дугаар зүйл. Төрийн захиргааны байгууллага, түүний чиг үүрэг

10.1. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газрын тохируулагч агентлаг мөн.

10.2. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах чиг үүрэгтэй байна:

10.2.1. олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандартыг суурь түвшинд хэрэгжүүлэх;

10.2.2. хэлэлцэн тохиролцогч улсын иргэний нисэхийн байгууллагуудтай хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох;

10.2.3. нийтийн эрх ашигт нийцүүлэн нислэгийн аюулгүй байдлын бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх;

10.2.4. иргэний нисэхийн дүрэм болон Чикагогийн конвенцийн стандартын зөрүүтэй байдлыг олон улсын иргэний нисэхийн байгууллагад мэдээлэх;

10.2.5. иргэний нисэхийн дүрмийг боловсруулж, батлуулах;

10.2.6. хэлэлцэн тохиролцогч улсын эрх бүхий байгууллагатай нислэгийн аюулгүй байдлын хяналтын чиглэлээр хамтын ажиллагааны гэрээ байгуулах;

10.2.7. агаарын хөлөг, техник үйлчилгээ, сургалтын байгууллага болон агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч, түүний нислэгийн ажилтанд үзлэг, шалгалт хийх;

10.2.8. иргэний нисэхийн үйлчилгээний байгууллагад үзлэг, шалгалт хийх.

11 дүгээр зүйл. Төрийн захиргааны байгууллагын дарга, түүний бүрэн эрх

11.1. Төрийн захиргааны байгууллагын дарга /цаашид дарга гэх/ иргэний нисэхийн мэргэжилтэй, тухайн салбартаа 15-аас доошгүй жил ажилласан, ашиг сонирхлын зөрчилгүй, аюулгүй байдлын хяналтын улсын байцаагчид тавих шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн байна.

11.2. Дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.2.1. иргэний нисэхийн аюулгүй байдлыг хариуцах;

11.2.2. агаарын хөлөг, түүний бүрдэл хэсэг болон иргэний нисэхийн байгууллагын үйл ажиллагаанд үзлэг, шалгалт хийх чиг үүрэгтэй хяналтын байцаагчийг томилох, чөлөөлөх;

11.2.3. зөвлөмжийн цуврал, маягт, бүртгэлийн дэвтэр, ерөнхий заавар, төлөвлөгөө болон техник технологийн баримт бичгийг батлах, тэдгээрт өөрчлөлт оруулах;

11.2.4. иргэний нисэхийн үйлчилгээний байгууллагад гэрчилгээ олгох;

11.2.5. нисэхийн мэргэшсэн ажилтны үнэмлэх, гэрчилгээ олгох;

11.2.6. агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ олгох;

11.2.7. агаарын хөлгийг бүртгэх, бүртгэлээс хасах, агаарын хөлгийн гэрчилгээ олгох, хүчингүй болгох;

11.2.8. аюулгүй байдлын зөвлөмжийг үндэслэн агаарын хөлгийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

11.2.9. иргэний нисэхийн дүрмээр зохицуулагдаагүй нислэгийн аюулгүй байдалд нөлөөлөх нөхцөл байдал шинээр үүссэн тохиолдолд тодорхой хугацаатай тушаал гаргаж, мэдээлэх;

11.2.10. нислэгт тэнцэх чадвараа алдсан агаарын хөлгийн нислэгийг зогсоох, гэрчилгээг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

11.2.11. тухайн нислэг нь хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд хохирол учруулж болзошгүй тохиолдолд нислэгийг зогсоох хүртэл арга хэмжээг авах;

11.2.12. энэ хууль болон албадан хэрэгжүүлэх дүрмийн дагуу хувь хүн, хуулийн этгээдэд сануулах, торгох, үнэмлэх, гэрчилгээг түдгэлзүүлэх болон хүчингүй болгох арга хэмжээ авах;

11.2.13. үнэмлэх, гэрчилгээ, эрх болон зөвшөөрөл олгох үзлэг, шалгалтын ажлын үнэлгээний хэмжээг тогтоох;

11.2.14. аэродромыг бүртгэх;

11.2.15. иргэний нисэхийн салбарын хөтөлбөрийг батлах.

12 дугаар зүйл. Эрх шилжүүлэх

12.1. Дарга хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгийн ажилтан, шүхэрчин, шүхрийн техникчийн үнэмлэх, гэрчилгээ олгох эрхийг нисэх клуб болон шүхрийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдэд бүхэлд нь эсхүл хэсэгчлэн тушаалаар тодорхой хугацаатай шилжүүлж болно.

12.2. Эрхээ шилжүүлсэн нь түүнийг нислэгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ИРГЭНИЙ НИСЭХИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТ, ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ

13 дугаар зүйл. Иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалт

13.1. Нисэхийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалт дараах чиглэлтэй байна:

13.1.1. нисэхийн мэргэшсэн ажилтны үнэмлэх, гэрчилгээжүүлэлт;

13.1.2. агаарын хөлгийн бүртгэл, нислэгт тэнцэх чадварын үнэлгээ;

13.1.3. нислэгийн үйл ажиллагаа;

13.1.4. агаарын навигацийн үйл ажиллагаа,

13.1.5. аэродром, аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагаа.

13.2. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага иргэний нисэхийн хяналт, зохицуулалтыг тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүүгийн чадавхитай байна.

14 дүгээр зүйл. Нисэхийн мэргэшсэн ажилтны үнэмлэх, гэрчилгээжүүлэлт

14.1. Иргэний нисэхийн дүрэмд заасан мэргэжил, туршлага, болон эрүүл мэндийн шаардлага хангасан хүсэлт гаргагчид нисэхийн мэргэшсэн ажилтны үнэмлэх, зэрэглэл болон эрүүл мэндийн гэрчилгээ олгоно.

14.2. Үнэмлэх, гэрчилгээнд эрх, хязгаарлалтыг заасан байна.

14.3. Нисэхийн мэргэшсэн ажилтан энэ хууль, иргэний нисэхийн дүрэм болон тухайн үнэмлэх, гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

15 дугаар зүйл. Техник үйлчилгээний байгууллага

15.1. Агаарын хөлөг, түүний бүрдэл хэсэгт бүрэн болон хэсэгчилсэн үйлчилгээ, засвар, өөрчлөлтийг иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн техник үйлчилгээний байгууллага гүйцэтгэнэ.

15.2. Хэлэлцэн тохиролцогч улсын эрх бүхий байгууллагаар гэрчилгээжсэн, холбогдох иргэний нисэхийн дүрмийн дагуу үзлэг, шалгалт хийх шаардлага хангасан агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагад бүрэн болон хэсэгчилсэн үйлчилгээ, засвар, өөрчлөлт хийхийг зөвшөөрч болно.

15.3. Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн техник үйлчилгээг дараах байгууллагын аль нэгээр гүйцэтгүүлнэ:

15.3.1. энэ хуулийн 15.1-д заасан гэрчилгээжсэн байгууллага;

15.3.2. нисэхийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч;

15.3.3. хэлэлцэн тохиролцогч улсын эрх бүхий байгууллагаар гэрчилгээжсэн болон хамтын ажиллагааны гэрээгээр заасан.

15.4. Техник үйлчилгээний байгууллага агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн техник үйлчилгээ болон засварыг гэрчилгээний эрх, хязгаарлалтын хүрээнд, техникийн болон үйл ажиллагааны батлагдсан зааврын дагуу гүйцэтгэнэ.

15.5. Техник үйлчилгээний байгууллага тухайн гэрчилгээнд заасан үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай бүтэц, инженер, техникийн ажилтан болон барилга байгууламж, төхөөрөмжтэй байна.

16 дугаар зүйл. Сургалтын байгууллага

16.1. Нислэгийн ажилтны сургалтын байгууллага иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн байна.

16.2. Сургалтын байгууллага гэрчилгээний эрх, хязгаарлалтын хүрээнд, батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалтын үйл ажиллагааг зохион байгуулна.

16.3. Сургалтын байгууллага тухайн гэрчилгээнд заасан сургалтыг зохион байгуулахад шаардлагатай бүтэц, багшлах бүрэлдэхүүн, хөтөлбөр, дадлагажуур болон тоног төхөөрөмжтэй байна.

17 дугаар зүйл. Хэлэлцэн тохиролцогч улсын нисэхийн баримт бичиг

17.1. Хэлэлцэн тохиролцогч улсын эрх бүхий байгууллагаас олгосон үнэмлэх, гэрчилгээг дараах нөхцөлд хүлээн зөвшөөрч болно:

17.1.1. нислэгийн ажилтны үнэмлэх Чикагогийн конвенцийн шаардлагад нийцсэн, түүнд байнгын хяналт тавьдаг бол;

17.1.2. агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ Чикагогийн конвенцийн шаардлагад нийцсэн түүнд байнгын хяналт тавьдаг бол.

17.3. Хэлэлцэн тохиролцогч улсаас олгосон мэргэжлийн үнэмлэх, эрүүл мэндийн гэрчилгээг тухайн ажилтны мэргэжил, эрүүл мэндийн хувьд ажил үүрэг гүйцэтгэх чадвартай болохыг нотлох баримтаар тооцож болно.

18 дугаар зүйл. Иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналтын улсын байцаагч, түүний бүрэн эрх

18.1. Иргэний нисэхийн байгууллагад үзлэг, шалгалтыг иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналтын улсын байцаагч /цаашид улсын байцаагч гэх/ хэрэгжүүлнэ.

18.2. Улсын байцаагч тухайн хяналт зохицуулалтын чиглэлээр мэргэшсэн, холбогдох хууль, иргэний нисэхийн дүрэм, заавар, иргэний нисэхийн талаарх олон улсын эрх зүйн зохицуулалтын талаар зохих мэдлэгтэй, Монгол Улсын иргэн байна.

18.3. Улсын байцаагч энэ хууль, иргэний нисэхийн дүрэм, зааврын хүрээнд иргэний нисэхийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлнэ.

18.4. Улсын байцаагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.4.1 Монгол Улсад нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлөгт саадгүй нэвтрэх;

18.4.2. Улсын байцаагч үзлэг шалгалт хийх зорилгоор дараах байгууллага, барилга байгууламжид аль ч үед саадгүй нэвтрэх:

18.4.2.1. агаарын тээвэрлэгчийн ажлын байр;

18.4.2.2. ангар, агуулах байр;

18.4.2.3. техник үйлчилгээний байгууллага;

18.4.2.4. засвар, үйлчилгээний газар;

18.4.2.5. агаарын хөлгийн зогсоол;

18.4.2.6. аэродром, нисэх буудлын байгууламж;

18.4.2.7. агаарын навигацийн байгууламж;

18.4.2.8. шатахуун хадгалах, түгээх байгууламж;

18.4.2.9. ачааны байгууламж;

18.4.2.10. нисэхийн сургалтын байгууллага;

18.4.2.11. нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага.

18.5. Хүний амь нас, эрүүл мэнд хүрээлэн буй орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулж байгаа, эсхүл учрах нь зохих ёсоор тогтоогдсон бөгөөд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд эдгээр зөрчлийг арилгах хүртэл агаарын хөлгийг түр саатуулах, аливаа этгээдийн иргэний нисэхийн бичиг баримтыг түр хураах, холбогдох үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн зогсоох, барилга байгууламж, машин тоног төхөөрөмжийн ашиглалтыг зогсооно.

18.6. Хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох иргэн, хуулийн этгээдээс шаардан гаргуулж авна.

18.7. Улсын байцаагч түүний эрхийн хүрээг тодорхой заасан үнэмлэхтэй байна.

18.8. Иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналтын улсын байцаагч тусгай зориулалтын хувцас, хэрэгсэлтэй байна.

19 дүгээр зүйл. Иргэний нисэхийн дүрмийн зохицуулалт

19.1. Иргэний нисэхийн аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагааг энэ хуульд нийцүүлэн гаргасан дүрмээр зохицуулна.

19.2. Иргэний нисэхийн дүрмийн зохицуулалт нь дүрэм, зөвлөмжийн цуврал, маягт болон бүртгэлийн дэвтрээс бүрдэнэ.

20 дугаар зүйл. Иргэний нисэхийн дүрмээр зохицуулах үйл ажиллагаа

- 20.1. Иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах дараах дүрмүүдтэй байна:
- 20.1.1. осол, зөрчлийг мэдээлэх болон албадан хэрэгжүүлэх арга хэмжээний;
- 20.1.2. агаарын хөлөг, бүтээгдэхүүн, эд ангийн гэрчилгээжүүлэх, агаарын хөлгийн бүртгэл, нислэгт тэнцэх чадварын удирдамж болон, техник үйлчилгээний;
- 20.1.3. аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны нийтлэг;
- 20.1.4. нисэхийн мэргэшсэн ажилтны үнэмлэх, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээний;
- 20.1.5. агаарын зайг тогтоох, ангилах болон агаарын зайн зохицуулалтын;
- 20.1.6. нислэгийн үйл ажиллагааны ерөнхий;
- 20.1.7 хэрэглэлийн . нислэгийн журмын;
- 20.1.8. хүнгүй агаарын хөлөг, аргамжаат шүхэр болон хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийг гэрчилгээжүүлэх;
- 20.1.9. шүхэр, хэт хөнгөн агаарын хөлөг болон нисэх клубийг гэрчилгээжүүлэх;
- 20.1.10. том, дунд, жижиг агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаа болон дотоод, гадаадын агаарын тээвэрлэгчийг гэрчилгээжүүлэх;
- 20.1.11. агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр болон аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагыг гэрчилгээжүүлэх;
- 20.1.12. нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх, хөдөө аж ахуйн агаарын хөлөг болон чөлөөт нисэхийн үйл ажиллагааг гэрчилгээжүүлэх;
- 20.1.13. агаарын хөлөг зохион бүтээх, үйлдвэрлэх болон техник үйлчилгээ хийх байгууллагыг гэрчилгээжүүлэх;
- 20.1.14. нислэгийн ажилтны сургалтын байгууллагыг гэрчилгээжүүлэх;
- 20.1.15. агаарын хөлгөөр аюултай барааг тээвэрлэх болон зохицуулалттай агаарын ачааны байгууллагыг гэрчилгээжүүлэх;
- 20.1.16. аэродром байгуулах болон аэродромын үйл ажиллагааг гэрчилгээжүүлэх;
- 20.1.17. агаарын навигацийн техник үйлчилгээ, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ, хэрэглэлийн нислэгийн журам зохиох, шалгалтын нислэг, нисэхийн цаг уурын болон нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагыг гэрчилгээжүүлэх;
- 20.1.18. Олон улсын гэрээ, конвенцид шинээр орсон зүйл, заалтын дагуу шаардлагатай гэж үзсэн бусад дүрэм.

21 дүгээр зүйл. Иргэний нисэхийн дүрмийн шаардлагаас чөлөөлөх

21.1. Тухайн дүрмээр хориглоогүй бол дараах нөхцөлд иргэний нисэхийн дүрмийн заалтаас ангид зохицуулж болно:

- 21.1.1. хүсэлт гаргагч дүрмийн тухайн заалтыг хүлээн зөвшөөрч болохуйц өөр хэлбэрээр хангах бол;
- 21.1.2. хүсэлт гаргагчийн хэрэгжүүлэхээр санал болгосон арга хэмжээ дүрмийн тухайн заалтыг хэрэгжүүлснээс илүү үр дүнтэй бол;
- 21.1.3. нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй болох нь тогтоогдсон бол.

21.2. Дарга иргэний нисэхийн дүрмийн заалтаас ангид зохицуулах журмыг баталж, мөрдөнө.

21.3. Иргэний нисэхийн дүрмийн тухайн заалтаас ангид зохицуулсан шийдвэрийг нийтэд мэдээлнэ.

22 дугаар зүйл. Иргэний нисэхэд ашиглах хэл

22.1. Иргэний нисэхэд ашиглах техникийн баримт бичгийг монгол, англи болон шаардлагатай гэж үзвэл Олон улсын иргэний нисэхийн байгууллагын хүлээн зөвшөөрсөн албан ёсны аль нэг хэл дээр хэрэглэж болно.

22.2. Агаарын навигацийн үйлчилгээнд монгол, англи хэл хэрэглэх ба шаардлагатай үед харилцан бүрэн ойлголцох өөр хэл хэрэглэж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ АГААРЫН ХӨЛӨГ, ТҮҮНД ХАМААРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

23 дүгээр зүйл. Агаарын хөлөг түүний бүрдэл хэсгийн бүртгэл

23.1. Төрийн захиргааны байгууллага агаарын хөлгийн үндэсний харьяаллын болон улсын бүртгэлийн тогтолцоотой байна.

23.2. Монгол Улсын иргэн, хуулийн этгээд өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа, бусад улсад бүртгэлгүй агаарын хөлгийг иргэний нисэхийн дүрмийн дагуу Монгол Улсад бүртгүүлнэ.

23.3. Монгол Улс болон гадаад улсад бүртгэлгүй агаарын хөлгөөр Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэхийг хориглоно.

23.4. Энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийг зөрчсөн, эсхүл нийтийн ашиг сонирхолд харшилсан тохиолдолд агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгоно.

23.5. Агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ тухайн агаарын хөлгийн үндэсний харьяаллыг гэрчлэх ба агаарын хөлгийн өмчлөлийг нотлохгүй.

23.6. Төрийн захиргааны байгууллага Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөг түүний бүрдэл хэсгийн эзэмшигч, өмчлөгчийн бүртгэлтэй байна.

24 дугаар зүйл. Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар

24.1. Монгол Улсад хүлээн зөвшөөрсөн агаарын хөлгийн маягийг нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж болно.

24.2. Үйлдвэрлэгч улсын эрх бүхий байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ хийснээр тухайн агаарын хөлгийн маягийг хүлээн зөвшөөрч болно.

24.3. Маягийн гэрчилгээний шаардлага хангасан, үзлэг, шалгалтаар нислэгийн аюулгүй байдлыг хангах нөхцөлд байгаа агаарын хөлөгт нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгоно.

24.4. Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээнд түүний хүчинтэй хугацаа, агаарын хөлгийн зориулалт, нислэгийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай ангилал, хязгаарлалт болон бусад мэдээллийг оруулна.

25 дугаар зүйл. Нислэгийн үйл ажиллагааны төрөл

25.1. Нислэгийн үйл ажиллагаа нь агаарын тээврийн болон ерөнхий зориулалтын чиглэлтэй байна.

25.2. Агаарын тээврийн үйл ажиллагаа нь агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн дараах үйл ажиллагаас бүрдэнэ.

25.2.1. 30-аас дээш зорчигчийн суудалтай эсхүл төлбөрт ачааллын багтаамж 3410 килограммаас дээш том нисэх онгоцны;

25.2.2. 10-30 зорчигчийн суудалтай эсхүл төлбөрт ачааллын багтаамж 3410 килограмм дунд нисэх онгоцны;

25.2.3. нисдэг тэрэг, эсхүл 9 ба түүнээс доош зорчигчийн суудалтай нисэх онгоцны;

25.3. Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа нь агаарын хөлгийн овор жингээс үл хамаарч тусгай зориулалтын нисэх, чөлөөт нисэх, нисэх клуб болон хувийн нислэгийн үйл ажиллагаанаас бүрдэнэ.

25.3.1. тусгай зориулалтын нисэхийн үйл ажиллагаанд дараах үйл ажиллагаа багтана:

25.3.1.1. хөдөө аж ахуйн болон аж ахуйн бусад агаарын хөлгийн үйл ажиллагаа;

25.3.1.2. нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх.

25.3.2. Чөлөөт нисэхийн үйл ажиллагаанд шүхэр, агаарын бөмбөлөг, хүнгүй, хэт хөнгөн, хөнгөн агаарын хөлгөөр зорчигчийг зардал хуваах хэлбэрээр тээвэрлэх үйл ажиллагаа багтана.

25.3.3. Өөрийн эзэмшлийн агаарын хөлгөөр нисэх клуб болон хувийн нислэгийн үйл ажиллагаа эрхлэгч дараах шаардлагыг хангасан байна.

25.3.3.1. нислэгт тэнцэх чадварын шаардлага хангасан агаарын хөлөгтэй байх;

25.3.3.2. хүчин төгөлдөр үнэмлэх, гэрчилгээ эзэмшдэг нислэгийн ажилтантай байх;

25.3.3.3. үйл ажиллагаандаа тохирсон заавар, журамтай байх.

25.4. Нисэх клуб болон хувийн нислэгийн үйл ажиллагааг зардал хуваах хэлбэрээр гүйцэтгэж болно.

25.5. Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаанд энэ хууль болон иргэний нисэхийн дүрмээс давсан хориг, хязгаарлалт тогтоохыг хориглоно.

25.6. Хувийн нислэгийн үйл ажиллагааны нислэгийн аюулгүй байдлыг агаарын хөлөг эзэмшигч хариуцна.

26 дугаар зүйл. Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ

26.1. Энэ хуулийн 34.1-ийн дагуу олгосон агаарын тээврийн эдийн засгийн зөвшөөрөл бүхий Монгол Улсын иргэн, хуулийн этгээд агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргасан бол энэ хууль болон холбогдох иргэний нисэхийн дүрмийн шаардлагад нийцүүлэн агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ олгоно.

26.2. Томилогдсон гадаадын агаарын тээвэрлэгч энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг хангасан нөхцөлд түүнд гадаадын агаарын тээвэрлэгчийн Монгол Улсын гэрчилгээ олгож болно.

26.3. Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг бусдад шилжүүлэхийг хориглоно.

27 дугаар зүйл. Агаарын тээвэрлэгчийн үүрэг

27.1. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй агаарын тээвэрлэгч дараах үүрэгтэй:

27.1.1. нислэгийн үйл ажиллагааг гэрчилгээний эрх, хязгаарлалт болон үйл ажиллагааны тодорхойлолтын хүрээнд гүйцэтгэх;

27.1.2. иргэний нисэхийн дүрмийн шаардлага хангасан удирдлага, зохион байгуулалтын бүтэцтэй байх;

27.1.3. үйл ажиллагаандаа тохирсон агаарын хөлөг болон шаардагдах тооны нислэгийн ажилтантай байх;

27.1.4. ашиглаж байгаа агаарын хөлөг болон түүний бүрдэл хэсгийн үзлэг, засвар үйлчилгээг гэрчилгээний эрх, хязгаарлалтын хүрээнд гүйцэтгэх;

27.1.5. агаарын хөлгийн осол, зөрчил давтан гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор дотоод шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэх;

27.1.6. аюултай барааг иргэний нисэхийн дүрэм болон Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Техникийн зааварчилгааны дагуу тээвэрлэх;

27.1.7. нислэгийн үйл ажиллагааны болон агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын шаардлагад нийцсэн заавар, журам боловсруулж мөрдөх, холбогдох дүрэм журмын дагуу нийтийн ашиг сонирхолд нийцсэн найдвартай үйлчилгээг үзүүлэх.

28 дугаар зүйл. Агаарын хөлгийн дарга, түүний бүрэн эрх

28.1. Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нислэгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор тухайн нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай үнэмлэх, гэрчилгээтэй нисэгчийг агаарын хөлгийн даргаар томилно.

28.2. Нислэгийн аюулгүй байдлыг хангах, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах зорилгоор багийн гишүүд болон зорчигчид шаардлага тавьж биелэлтийг хангуулна.

28.3. Агаарын хөлгийн дарга нислэгийн үйл ажиллагаатай холбоотой эцсийн шийдвэрийг дагнан гаргана.

28.4. Агаарын хөлгийн дарга иргэний нисэхийн дүрэмд зааснаас өөр шийдвэрийг дараах онцгой нөхцөлд гаргах эрхтэй:

28.4.1. хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд аюул тулгарсан бол;

28.4.2. иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг мөрдөх тухайн онцгой нөхцөлийг хүндрүүлэхээр бол;

28.5. Агаарын хөлгийн дарга энэ зүйлд заасан онцгой нөхцөлийн үед иргэний нисэхийн дүрэмд зааснаас өөр шийдвэр гаргасан бол энэ тухай агаарын навигацгийн үйлчилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

28.6. Гадаад улсын агаарын зайд нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн дарга албадан саатуулагдах нөхцөл байдалд орсон тохиолдолд тухайн улсын эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагыг дагаж мөрдөх үүрэгтэй.

29 дүгээр зүйл. Нислэгийн үйл ажиллагаанд хориглох зүйл

29.1. Нислэгийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

29.1.1. бүртгэлгүй, эсхүл нислэгт тэнцэх чадварын шаардлага хангаагүй агаарын хөлгөөр, эсхүл нисэх эрхгүй этгээд гүйцэтгэх;

29.1.2. агаарын хөлөгт гарал үүсэл тодорхойгүй, үйлдвэрлэгчийн техникийн тодорхойлолтод нийцээгүй эд анги ашиглах;

29.1.3. иргэний нисэхийн дүрэм, үнэмлэх гэрчилгээний эрх, хязгаарлалтыг зөрчин нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа агаарын хөлөг, түүний бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийх;

29.1.4. агаарын хөлөгтэй холбоотой ажил, үйлчилгээнд нислэгийн ажилтны үнэмлэх, гэрчилгээгүй этгээдийг ажиллуулах, гэрчилгээгээр олгосон эрхээс хэтэрсэн ажил үүрэг гүйцэтгүүлэх;

29.1.5. нислэгийн үед агаарын хөлгийн даргын зөвшөөрөлгүйгээр нисэх багийн бүхээгт нэвтрэх.

30 дугаар зүйл. Нислэгийн үеийн дэг журам

30.1. Зорчигч агаарын хөлгийн багийн гишүүдээс өгсөн үүрэг, зааварчилгааг нислэгийн туршид дагаж мөрдөх үүрэгтэй.

30.2. Багийн гишүүн нислэгийн үед аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй үйлдэл гаргасан, гаргахыг завдсан зорчигчийг аюулгүй болгох арга хэмжээ авна.

30.3. Энэ хуулийн 30.1-д заасан шаардлагыг биелүүлээгүй, 30.2-т заасан дэг журам зөрчсөн зорчигчийн үйлдэлд албадлагын арга хэмжээ авах журмыг Сайд, Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

ТАВДУГААР БҮЛЭГ. АГААРЫН ТЭЭВРИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЗОХИЦУУЛАЛТ

31 дүгээр зүйл. Агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалт

31.1. Агаарын тээврийн үйлчилгээг үр ашигтай, хүртээмжтэй хөгжүүлэх зорилгоор эдийн засгийн зохицуулалтыг хэрэгжүүлнэ.

31.2. Эдийн засгийн зохицуулалтын дүрмээр дараах үйл ажиллагааг зохицуулна:

31.2.1. агаарын тээврийн үйлчилгээ эрхлэх эдийн засгийн зөвшөөрөл олгох;

31.2.2. олон улсын агаарын тээвэрлэгчийг томилох;

31.2.3. агаарын тээвэрлэгчийн хариуцлагын даатгал;

31.2.4. тээвэрлэлтийн гэрээ, зорчигчийн бүртгэлд тавигдах шаардлага;

31.2.4. статистикийн мэдээлэл;

31.2.5. иргэний нисэхийн төлбөртэй үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээг тогтоох, зарцуулах.

32 дугаар зүйл. Агаарын тээвэрлэгчийн даатгал

32.1. Агаарын тээвэрлэгч зорчигчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учрах хохирлыг барагдуулах зорилготой хариуцлагын даатгалтай байна.

32.2. Агаарын тээвэрлэгч албан үүргээ гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн багийн гишүүдийн амь нас, эрүүл мэндийг заавал даатгуулна.

32.3. Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх агаарын хөлөг гуравдагч этгээдэд учрах хохирлыг хариуцах баталгаа бүхий даатгалтай байна.

32.4. Олон улсын агаарын тээврийн үйл ажиллагаанд зорчигч, гуравдагч этгээд амь насаа алдсан, эрүүл мэнд, эд хөрөнгөөр хохирсон, ачаа тээш, шуудан гэмтэж, алдагдсан бол Монреалийн конвенцийн заалтыг баримтлан агаарын тээвэрлэгч нөхөн төлбөр олгоно.

32.5. Орон нутгийн агаарын тээврийн үйл ажиллагаанд зорчигч, гуравдагч этгээд амь насаа алдсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлснээс доошгүй хэмжээний төгрөг, эрүүл мэндээр хохирсон бол эмчилгээний болон бусад зардлыг олгох, эд хөрөнгөөр хохирсон, ачаа тээш, шуудан гэмтэж, алдагдсан бол хохирлыг барагдуулна.

33 дугаар зүйл. Агаарын тээвэрлэгчийн өмчийн хувь хэмжээ

33.1. Монгол Улсын агаарын тээвэрлэгчийн өмчийн 51-ээс доошгүй хувийг Монгол Улсын иргэн, эсхүл хуулийн этгээд өмчилнө.

33.2. Агаарын тээвэрлэгч өөрийн өмчийн хувь хэмжээний аливаа өөрчлөлтийг эрх бүхий этгээдэд заавал мэдэгдэнэ.

34 дүгээр зүйл. Гадаадын агаарын тээвэрлэгчид зөвшөөрөл олгох

34.1. Дараах шаардлага хангасан гадаадын агаарын тээвэрлэгчид эдийн засгийн зөвшөөрөл олгоно:

34.1.1. гадаадын улсын агаарын тээвэрлэгч тухайн улсын Засгийн газрын эрх бүхий байгууллагаас олон улсын агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэхээр Монгол Улстай байгуулсан гэрээний нөхцөлийн дагуу томилогдсон байх;

34.1.2. олон улсын агаарын тээврийн үйл ажиллагааг зохих ёсоор гүйцэтгэх чадвартай, энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг хангасан байх;

34.1.3. Монреалийн конвенцийн шаардлагыг хангасан хариуцлагын даатгалтай байх;

34.2. Гадаадын агаарын тээвэрлэгч энэ хууль, иргэний нисэхийн дүрэм болон энэ зүйлийн 34.1-д заасны дагуу олгосон эдийн засгийн зөвшөөрлийн эрх, хязгаарлалтыг зөрчсөн бол Сайд тухайн зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгоно.

34.3. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд, энэ хуулийн 34.1-д заасны дагуу олгосон зөвшөөрлийг түдгэлзүүлэх, өөрчлөх, эсхүл хүчингүй болгох хүсэлтийг Сайдад гаргаж болно.

34.4. Гадаадын агаарын тээвэрлэгчийг Монгол Улсын нутаг дэвсгэрийн дотор нэг цэгээс, нөгөө цэгийн хооронд арилжааны агаарын тээврийн нислэг гүйцэтгүүлэхгүй.

35 дугаар зүйл. Тээвэрлэлтийн үнэ хөнгөлөлт

35.1. Зорчигч, ачаа тээврийн үнэ хөлсний хэмжээг оролцогч талуудын тохиролцож байгуулсан гэрээгээр тогтооно.

35.2. Засгийн газрын шийдвэрээр гүйцэтгэсэн зорчигч, ачаа тээврийн үйлчилгээнд нөхөн олговор олгоно.

35.3. Төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр шинэ чиглэлд агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэхэд хөнгөлөлт олгож болно.

35.4. Өрсөлдөөнгүй, давамгайл байдал үүссэн болон энэ хуулийн 35.2, 35.3-д зааснаас бусад тохиолдолд орон нутгийн агаарын тээврийн үйлчилгээний төлбөрийн хэмжээг төрөөс зохицуулахгүй.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. АГААРЫН НАВИГАЦИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

36 дугаар зүйл. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага

36.1. Монгол Улсын агаарын зайд агаарын навигацийн үйлчилгээг энэ хуулийн дагуу иргэний нисэхийн холбогдох дүрмээр гэрчилгээжсэн төрийн өмчит агаарын навигацийн үйлчилгээний байгууллага /цаашид агаарын навигацийн үйлчилгээний байгууллага гэх/ Монгол Улсын нэрийн өмнөөс үзүүлнэ.

36.2. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нислэгийн бүх үе шатанд үзүүлэх нислэгийн хөдөлгөөний зохицуулалт, холбоо, навигаци, ажиглалтын, нисэхийн мэдээллийн, нисэхийн цаг уурын үйлчилгээ болон эрэн хайх, авран туслах үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл дамжуулах цогц үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

36.3. Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх замыг стандартын дагуу тоноглосон байна.

37 дугаар зүйл. Нислэгийн хөдөлгөөний зохицуулалт

37.1. Монгол Улсын агаарын зайд агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээг иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн байгууллага гүйцэтгэнэ.

37.2. Агаарын хөлөг Монгол Улсын хилийг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлийн дагуу орох, гарах цэгээр нэвтэрч, тогтоосон агаарын замаар нислэг үйлдэнэ.

37.3. Монгол Улсын агаарын хилийг нэвтрэх нислэгийн хөдөлгөөний зөвшөөрлийг нислэгийн удирдагчаас авна.

37.4. Монгол Улсын агаарын зайн ангилал, бүтэц, зохион байгуулалт, сүлжил, агаарын хөлгийн хоорондын аюулгүйн зайчлал нь олон улсын зөвлөмж, шаардлагад нийцсэн байна.

38 дугаар зүйл. Аюул тулгарсан агаарын хөлөг

38.1. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага Монгол Улсын нутаг дэвсгэрт аюул тулгарсан агаарын хөлгийн талаар зохих журмын дагуу холбогдох байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

38.2. Чикагогийн конвенцийн 25 дугаар зүйлд тодорхойлсон аюул тулгарсан агаарын хөлөгт тусламж үзүүлэх, эрэн хайх, авран туслах үйл ажиллагааг тухайн агаарын хөлгийг эзэмшигч, эсхүл бүртгэгч улсын эрх бүхий байгууллага нь Монгол Улсын онцгой комисстой хамтран гүйцэтгэнэ.

38.3. Нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэд аюул тулгарсан агаарын хөлгийн талаар холбогдох байгууллагад нэн даруй мэдээлэх, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, эмнэлгийн болон бусад зайлшгүй шаардлагатай тусламж үзүүлэх үүрэгтэй.

38.4. Аюул тулгарсан агаарын хөлгийг эрэн хайх, авран туслахтай холбогдон гарсан зардлыг тухайн агаарын хөлгийн эзэмшигч буюу өмчлөгчөөс гаргуулж болно.

ДОЛООДУГААР БҮЛЭГ. АЭРОДРОМ, НИСЭХ БУУДАЛ

39 дүгээр зүйл. Аэродром байгуулах, ашиглах

39.1. Монгол Улсын иргэн, хуулийн этгээд иргэний нисэхийн дүрмийн дагуу аэродром байгуулна.

39.2. Агаарын тээвэрлэгчийн нислэгийн үйл ажиллагаанд ашиглах аэродром иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн байна.

39.3. Нисэхийн мэдээллийн эмхтгэлд нийтэд үйлчлэхээр бэлэн байдлыг зарласан аэродром нислэгийн аюулгүй байдлыг хангах бодит шаардлагаас бусад үед агаарын хөлөгт үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, үйл ажиллагаагаа зогсоохыг хориглоно.

40 дүгээр зүйл. Нисэх буудлын үйлчилгээ

40.1. Нисэх буудлын үйлчилгээний байгууллага аэродромын гэрчилгээ эзэмшигч байна.

40.2. Нисэх буудлын үйлчилгээний байгууллага олон улсын болон орон нутгийн нислэгт нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалт, аэродром, нисэхийн хангамж, газрын үйлчилгээ болон бусад нисэхийн ба нисэхийн бус үйлчилгээ үзүүлж болно.

41 дүгээр зүйл. Аэродромын аюулгүйн бүс

41.1. Иргэний нисэхийн дүрмийн шаардлагын дагуу аэродром эзэмшигч аймаг, сум, нийслэлийн Засаг даргатай хамтарч аэродром орчмын аюулгүйн бүсийг тогтооно.

41.2. Аэродромын аюулгүйн бүсэд нислэгийн аюулгүй байдалд нөлөөлөх үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх жагсаалт, барилга байгууламжийн өндрийн хязгаарлалтыг иргэний нисэхийн дүрмээр зохицуулна.

41.3. Аэродромын аюулгүйн бүсэд агаарын хөлгийн чиг баримжаа тогтооход зориулсан аюулгүй байдлын дохио, тэмдэгтэй ижил төстэй зүйл байрлуулахыг хориглоно.

42 дугаар зүйл. Дохио, тэмдэг

42.1. Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч аэродром, түүний орчинд агаарын хөлөг хөөрөх, буух, явгалах үед агаарын хөлгийн чиг баримжаа тогтооход зориулсан аэродромын дохио, тэмдгийг иргэний нисэхийн дүрэмд заасны дагуу байрлуулна.

42.2. Аэродромын аюулгүйн бүсэд барилга байгууламж өмчлөгч буюу эзэмшигч агаарын хөлгийн нислэгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор уг барилга байгууламж дээр аюулгүй байдлын дохио, тэмдгийг иргэний нисэхийн дүрэмд заасны дагуу байрлуулна.

НАЙМДУГААР БҮЛЭГ. НИСЭХИЙН АЮУЛГҮЙН ХАМГААЛАЛТ

43 дугаар зүйл. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ

43.1. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ дараах төрөлтэй байна:

43.1.1. аюулгүйн үзлэг;

43.1.2. харуул хамгаалалт.

43.2. Аюулгүйн үзлэгийг иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн байгууллага гүйцэтгэнэ.

43.3. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага аюулгүйн хамгаалалттай холбоотой хууль, тогтоомжийг зөрчсөн этгээдийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх зорилгоор саатуулна.

43.4. Иргэний нисэхийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагууд иргэний нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах, таслан зогсооход шаардлагатай арга хэмжээг хууль болон хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлнэ.

44 дүгээр зүйл. Аюулгүйн үзлэг, хамгаалалт

44.1. Олон улсын нисэх буудал болон түүний аюулгүйн бүсэд байрлах агаарын навигацийн байгууламжийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн байна.

44.2. Агаарын хөлгийн багийн гишүүн, зорчигчийн бие болон тээшинд агаарын тээвэрлэгч буюу эрх бүхий байгууллага иргэний нисэхийн дүрмийн дагуу үзлэг хийнэ.

44.3. Зорчигч аюулгүйн үзлэг хийлгэхээс татгалзсан тохиолдолд агаарын хөлгөөр тээвэрлэх гэрээг цуцална.

44.3. Аюулгүйн үзлэг, хамгаалалт шаардлагатай нисэх буудал болон агаарын навигацийн байгууламжийн жагсаалтыг дарга батална.

**ЕСДҮГЭЭР БҮЛЭГ.
АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ**

45 дугаар зүйл. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба

45.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт гарсан агаарын хөлгийн осол, зөрчлийг Чикагогийн конвенцийн 13 дугаар хавсралтын дагуу шинжлэн шалгах, ангилах, бүртгэх ажиллагааг Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба гүйцэтгэнэ.

45.2. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа нь аливаа этгээдийн гэм бурууг тогтоохгүй.

45.3. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүтцэд байх ба шинжлэн шалгах үйл ажиллагаа хараат бус, бие даасан байна.

45.4. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба энэ хуулиар олгогдсон эрхийн хүрээнд шинжлэн шалгах ажиллагаа гүйцэтгэхэд хүрэлцэхүйц хэмжээний төсөвтэй байна.

45.5. Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг тус улсын нутаг дэвсгэрийн гадна осол, ноцтой зөрчилд өртсөн үед шинжлэн шалгах ажиллагааг олон улсын хэлэлцээрийн дагуу гүйцэтгэх ба Монгол Улсын нэрийн өмнөөс Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба оролцож болно.

45.6. Төрийн бусад байгууллага Чикагогийн конвенцийн Хавсралт 13-ын зорилгоор агаарын хөлгийн осол, зөрчлийн шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэхийг хориглоно.

45.7. Энэ хуулийн 45.6-д заасны дагуу хууль хяналтын болон бусад байгууллага агаарын хөлгийн осол, зөрчлийг энэ хуульд зааснаас өөр зорилгоор шалгах ажиллагаанд хамаарахгүй.

45.8. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба агаарын хөлгийн осол, зөрчилтэй холбоотой мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийж, түүний шалтгаан болон нөлөөлсөн хүчин зүйлийг тогтоон, тайлан гаргана.

45.9. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба нислэгийн аюулгүй байдлыг сайжруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор шинжлэн шалгах ажиллагааны аль ч үе шатанд Аюулгүй байдлын зөвлөмж гаргаж болно.

45.10. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албаны шинжлэн шалгагчийг аливаа этгээдийн гэм бурууг тогтоох зорилгоор захиргааны болон иргэн, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон шүүн таслах ажиллагаанд гэрчээр оролцуулахыг хориглоно.

45.11. Шинжлэн шалгах баг осол болсон газарт ажиллахад шаардлагатай хамгаалах хувцас хэрэгсэл, төхөөрөмж болон холбоо, тээврийн хэрэгслээр хангагдсан байна.

46 дугаар зүйл. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах үйл ажиллагаа

46.1. Агаарын хөлөг өмчлөгч эзэмшигч, нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч, агаарын хөлгийн дарга, нисэх багийн гишүүд, аэродром болон агаарын навигацийн үйлчилгээний байгууллагын ажилтан агаарын хөлгийн осол, зөрчлийн дэлгэрэнгүй мэдээллийг Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албанд нэн даруй, боломжит хэлбэрээр өгнө.

46.2. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба ослын мэдээллийг хүлээн авмагц шинжлэн шалгах ажиллагааг нэн даруй эхлүүлнэ.

46.3. Осол, зөрчилд өртсөн агаарын хөлөгтэй холбоотой эд мөрийн баримтыг агаарын хөлөг өмчлөгч эзэмшигч болон холбогдох бусад этгээд шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэж дуусах хүртэл хадгалж, хамгаална.

46.4. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр агаарын хөлгийн осол гарсан үед иргэн, нутгийн захиргааны байгууллага, онцгой байдлын газар, цагдаа болон зэвсэгт хүчний анги салбарууд Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албаны үйл ажиллагаанд шаардлагатай туслалцааг үзүүлнэ.

47 дугаар зүйл. Ерөнхий шинжлэн шалгагч, түүний бүрэн эрх

47.1. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албыг Ерөнхий шинжлэн шалгагч удирдана.

47.2. Ерөнхий шинжлэн шалгагч шинжлэн шалгах чиглэлээр мэргэшсэн, холбогдох хууль, иргэний нисэхийн дүрэм, заавар, иргэний нисэхийн талаарх олон улсын эрх зүйн зохицуулалтын талаар зохих мэдлэгтэй, Монгол Улсын иргэн байна.

47.3. Ерөнхий шинжлэн шалгагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

47.3.1. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албаны ажилтан, шинжлэн шалгагчийг томилох, чөлөөлөх;

47.3.2. агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах багийн ахлагч болон гишүүдийг томилох;

47.3.3. агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааг зохион байгуулах;

47.3.4. ослын газрыг хамгаалалтад авах асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

47.3.5. шинжлэн шалгах ажиллагааны эцсийн тайланг батлах;

47.3.6. агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албаны төсвийг хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах;

47.3.7. шинжлэн шалгах ажиллагаанд мөрдөх дотоод үйл ажиллагааны заавар, журмыг батлах.

48 дугаар зүйл. Шинжлэн шалгагч, түүний бүрэн эрх

48.1. Шинжлэн шалгагч нь агаарын тээврийн нисэгчийн зэрэглэлтэй нисэгч, агаарын хөлгийн инженер эсхүл шинжлэн шалгах болон нислэгийн хөдөлгөөний удирдлагын чиглэлээр мэргэшсэн байна.

48.2. Шинжлэн шалгагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

48.2.1. албан үүргээ гүйцэтгэхдээ агаарын хөлгийн осол, зөрчилтэй холбоотой барилга байгууламжид ямар ч цагт саадгүй нэвтрэх, холбогдох эд мөрийн баримтыг гаргуулах;

48.2.2. шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагатай мэдээ, судалгаа, тодорхойлолт болон бусад нотлох баримтыг холбогдох хувь хүн, хуулийн этгээдээс шаардан авах;

48.2.3. Ерөнхий шинжлэн шалгагчаас олгосон бусад эрх.

49 дүгээр зүйл. Шинжлэн шалгах багийн ахлагч, түүний бүрэн эрх

49.1. Шинжлэн шалгах багийн ахлагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

49.1.1. Агаарын хөлгийн осол, зөрчил болсон газарт ямар ч цагт саадгүй нэвтрэх, шинжлэн шалгах ажиллагаанд хамааралтай ослын үлдэгдэл, бүх төрлийн эд зүйлст хяналтаа тогтоох;

49.1.2. нислэгийн бичлэгийн төхөөрөмж, тухайн нислэгийн үйл ажиллагаатай холбоотой агаарын навигацийн үйлчилгээний бичлэгүүд зэрэг бусад нотлох баримтыг өөрийн хяналтад авах;

49.1.3. шинжлэн шалгах ажиллагааг цаг алдалгүй эхлүүлэх зорилгоор холбогдох эд мөрийн баримт, агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн үлдэгдлийг өөрийн хяналтад авах;

49.1.4. шинжлэн шалгах ажиллагааны явцад эд мөрийн баримтыг хамгаалах, агаарын хөлөг, түүний үлдэгдэл байгаа бүсэд зөвшөөрөлгүй этгээд нэвтрэх, эд зүйл үрэгдэж гэмтэх, алдагдахаас хамгаалах боломжит бүх арга хэмжээг авах;

49.1.5. ослын газрыг хамгаалалтад авах зорилгоор эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;

49.1.6. шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай ажиглагч, оролцогчийг томилох;

49.1.7. шинжлэн шалгах ажиллагааны явцыг ерөнхий шинжлэн шалгагчид танилцуулах, ослын боломжит шалтгаан, нөлөөлсөн байж болох хүчин зүйлд тулгуурлан Аюулгүй байдлын зөвлөмж гаргах ажиллагааг зохион байгуулах;

49.1.8. ослын газрын хамгаалалтыг буулгах, шинжлэн шалгах ажиллагаанд цаашид шаардлагагүй болсон агаарын хөлөг, түүний бүрдэл хэсэг, эд зүйлсийг хадгалалтаас чөлөөлөх;

49.1.9. шинжлэн шалгах ажиллагааны тайлангийн төслийг гаргах;

49.1.10. хууль тогтоомжоор олгосон бусад бүрэн эрх.

50 дугаар зүйл. Шинжлэн шалгах ажиллагааны тайлан

50.1. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба эцсийн тайланг гаргахаас өмнө тухайн осол, зөрчлийн шинжлэн шалгах ажиллагаанд хамааралтай байгууллага, хамтран оролцсон улс болон эрх бүхий байгууллагуудаас санал авахаар тайлангийн төслийг хүргүүлнэ.

50.2. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба агаарын хөлгийн осол, зөрчил давтан гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор шинжлэн шалгах ажиллагааны тайланг боломжит богино хугацаанд гаргана.

50.3. Агаарын хөлгийн осол, зөрчлийн шинжлэн шалгах ажиллагааны тайлан болон аюулгүй байдлын зөвлөмжийг аливаа этгээдийн гэм бурууг тогтоох зорилгоор захиргааны хариуцлага хүлээлгэх, хянан шийдвэрлэх болон шүүн таслах ажиллагаанд нотлох баримтаар ашиглахгүй.

51 дүгээр зүйл. Аюулгүй байдлын зөвлөмж

51.1. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба нислэгийн аюулгүй байдлыг сайжруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор шинжлэн шалгах ажиллагааны аль ч үе шатанд аюулгүй байдлын зөвлөмж гаргаж болно.

51.2. Аюулгүй байдлын зөвлөмжийг агаарын хөлөг үйлдвэрлэгч, иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, агаарын тээвэрлэгч болон бусад холбогдох байгууллагад, шаардлагатай бол Олон улсын иргэний нисэхийн байгууллагад хүргүүлнэ.

51.3. Аюулгүй байдлын зөвлөмжийг хүлээн авсан этгээд зөвлөмжийн дагуу шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн 90 хоногийн дотор эргэж мэдэгдэнэ. Хэрэгжүүлэх боломжгүй бол үндэслэл бүхий тайлбар гаргана.

51.4. Энэ хуулийн 51.3-т заасны дагуу аюулгүй байдлын зөвлөмжийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь хүлээн зөвшөөрөхгүй байх бодит үндэслэл байгаа бол тайлбарыг Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албанд нэн даруй хүргүүлнэ.

52 дугаар зүйл. Шинжлэн шалгах ажиллагааг сэргээх

52.1. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах ажиллагааны эцсийн тайлан гарсны дараа тайлангийн дүгнэлтийг өөрчилж болох баримт, нөхцөл байдал шинээр илэрсэн бол Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба шинжлэн шалгах ажиллагааг сэргээх үүрэгтэй.

АРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

53 дугаар зүйл. Иргэний нисэхийн үйл ажиллагааны санхүүжилт

53.1. Иргэний нисэхийн хяналт, зохицуулалт, агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалт, агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах, төрийн өмчит агаарын навигацийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааны зардлыг улсын төсөв болон агаарын навигацийн хураамжийн орлогоос санхүүжүүлнэ.

53.2. Энэ хуулийн 53.1-т заасан агаарын навигацийн хураамжийн орлогын санхүүжилт тухайн жилийн нийт орлогын наймаас доошгүй хувь байна.

53.3. Энэ хуулийн 53.1-т заасан иргэний нисэхийн үйл ажиллагааны санхүүжилт эдгээр үйл ажиллагааг аюулгүй, тасралтгүй, үр ашигтай явуулахад хүрэлцэхүйц байна.

53.4. Энэ хуулийн 53.2-т заасан санхүүжилтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн болон иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Сайд тогтоож, жил бүрийн төсөвт тусгана.

54 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

54.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

54.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

55 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

55.1. Энэ хуулийг 2021 оны дүгээр сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ